



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 18 өдөр

Дугаар А/575

Алтай хот

“Аварзэд-100” түүх ба орчин үе эрдэм
шинжилгээний бага хурал зохион
байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, 4.1 дэх хэсэг, аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 35 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад явдлын яамны сайд агсан С.Аварзэдийн мэндэлсний 100 жилийн ойг тохиолдуулан “Аварзэд-100” Түүх ба орчин үе эрдэм шинжилгээний бага хурлыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр Алтай хотод зохион байгуулж, ажлын хэсгийг нэгдүгээр, шаардагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Шаардагдах 4,440,000 (Дөрвөн сая дөрвөн зуун дөчин мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй.


3.Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах ажлын хөтөлбөр боловсруулан батлуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсэг (П.Хулан)-т, Цогт сумд зохион байгуулагдах үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулан зохион байгуулж ажиллахыг сумын Засаг дарга (Л.Насанбуян)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20 ⁰⁹ оны ⁰⁹
дугаар сарын ¹³ -ны өдрийн ¹⁵⁵ дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч : П.Хулан	(Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Гишүүдэд: М.Алтангэрэл	(аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга) (зөвшилцсөнөөр)
С.Мөнхжаргал	(Нийгмийн бодлогын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Ж.Амгаланбаатар	(Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Т.Эрхэмбаяр	(Инноваци судалгаа, бизнес хөгжлийн төвийн захирал)
Э.Отгонбаатар	(Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын дарга)
Ж.Уранчимэг	(Биеийн тамир спортын газрын дарга)
А.Алтанхуяг	(Есөнбулаг сумын Засаг дарга)
Л.Насанбуян	(Цогт сумын Засаг дарга)
Нарийн бичгийн дарга : С.Цагаанбаатар	(Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

__оОо__

Аймгийн Засаг даргын 20²² оны 09
дугаар сарын 14 -ны өдрийн 1575 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

№	Нэр, төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Хэвлэлтийн зардал (Үйл ажиллагааны баннер Стенд)	-	500,000	500,000
2.	Үзэсгэлэнгийн зардал	25 ширхэг	63,600	1,590,000
3.	Хүндэт зочдод хүндэтгэл үзүүлэх	30	15,000	450,000
4.	Хүчит 32 бөхийн барилдааны зардал	-	-	1,900,000
Нийт:				4,440,000

__оОо__